

РОССИЙСКАЯ АКАДЕМИЯ НАУК
Институт восточных рукописей

МОНГОЛЬСКАЯ АКАДЕМИЯ НАУК
Институт языка и литературы



З.К. КАСЬЯНЕНКО – **УЧИТЕЛЬ И МОНГОЛОВЕД**

МАТЕРИАЛЫ

Международной конференции, посвященной
90-летию российского монголоведа З. К. Касьяненко

30 сентября – 1 октября, 2015 г.

Санкт Петербург

Санкт-Петербург
Улан-Батор
2016

МОНГОЛ ХЭЛНИЙ БИЕЭР ТӨГСГӨХ НӨХЦӨЛИЙН ДАРААХ “–ДАА⁴” НЭМЭЛТ ХЭЛБЭРИЙН ИЛТГЭХ БАЙМЖ УТГА

Аннотация. В данной статье сделана попытка раскрыть значения употребления частицы (например: -даа⁴) в монгольском языке в шести условиях при повелительной форме глаголов со значением пожелания, совета, просьбы, подтверждения, требования и поручения.

Ключевые слова: конечная частица -даа⁴, служебные слова, повелительное наклонение, модальное значение

Энэхүү судалгаагаараа монгол хэлний биеэр төгсгөх нөхцөл буюу үйл үгийн төгсгөх нөхцөлийн үндсэн утганд нэмэлт утга оруулдаг зарим сул үгсийн илрүүлэх утгын онцлогийг өгүүлэхийг зорьсон юм.

Хэл шинжлэлд баймж утга илрүүлдэг хэлзүйн хэлбэржилтийг “үйл үгийн төлөв” хэмээдэг бөгөөд монгол хэлний үйл үгийн “цаг заах”, “захирах хүсэх” хэлбэр нь үйлийн бодит байдалд хандах баймж чанарыг илэрхийлдэг учраас ийнхүү төлөвт тооцогддог байна.

“Захирах хүсэх төлөв”-т хамаарагдах бүлэг нөхцөл нь “үйлийн биед хамаатуулах”, “өгүүлбэрийг төгсгөх граммем”, “үйлийн төгсгөх”, “үйлийн биеэр төгсгөх”, “үйлийн хамаатуулах” нөхцөл зэргээр нэрлэгдэж ирсэн байна.

Үйлийн төгсгөх нөхцөлүүд:

1. Эдгээр нөхцөлөөр хэлбэржсэн үйл үг ямагт өгүүлбэр төгсгөж төгс өгүүлэхүүн болдог.

2. Төрөл бүрийн баймж харьцаа заадаг.

3. Үйлийн төгсгөх нөхцөлүүд нь үйл үгийн бүтцийн эцсийн туйл болдог.

Орчин цагийн монгол хэлэнд баймж харьцааг үйлийн үндсэнд үйлийн төгсгөх нөхцөлийг залгаж нийлэг аргаар, сул (чимэх) үгсээр, мөн төрөл бүрийн аялгаар тус тус илрүүлдэг бөгөөд үлэмж бүтээлч, нарийн зүй тогтолтой нийлэг арга нь үйл үгийн төлөв юм. Тухайлбал, үйлийн биеэр төгсгөх нөхцөлөөр хэлбэржсэн үйл өгүүлэхүүний дараа төрөл бүрийн нэмэлт баймж утгыг илрүүлдэг үгс ордог байна. Эдгээр үгс нь тухайн өгүүлбэрт өгүүлэгчийн сэтгэлийн өнгө аясыг илтгэхэд нэмэлт үүрэг гүйцэтгэдэг тул “нэмэлт хэлбэр” ч гэж тодорхойлдог ба тухайн өгүүлбэрээр илрэх утгыг ялгах, ерөнхийлөх, батлах, магадлах, үгүйсгэх, эргэлзэх, тааварлах, төсөөлөх, хориглох зэргээр нэмэн дэлгэрүүлж баймж утгын судлалд чухал үүрэг гүйцэтгэдэг ажээ.

Эрдэмтэн судлаач Ц. Өнөрбаян “...өгүүлбэрийн баймж чанар нь өгүүлэхүүн чанартайгаа нарийн шүтэлцсэн харьцаатай бөгөөд цаг, бие, төлөв нь баймж чанартай хослон өгүүлэхүүн гишүүндээ төвлөрдөг” хэмээн дурдаад, цаг, бие, төлөвийн нөхцөлүүд нь баймж утга илтгэх байдлаараа харилцан адилгүйн нотолгоо бол үйлийн биеэр төгсгөх нөхцөлд баймж утга голлох үүрэгтэй байхад цагаар төгсгөх нөхцөлүүдэд дагалт шинжтэй байдаг байна. Ийм ч учраас өгүүлэхүүн гишүүнийг угтах ба дагах төрөл бүрийн баймж утгатай чимэх үгс үүсчээ” хэмээсэн сонирхолтой дүгнэлт хийжээ [Өнөрбаян 1996].

Үүнээс үзэхэд өгүүлэхүүний хэлзүйн хэлбэрээр илрэх баймж утга нь өргөн цар хүрээтэй байвал түүний дараа орох чимэх үгийн тоо цөөн байдаг нь тодорхой байна.

Монгол хэлний биеэр төгсгөх нөхцөл (-я, /-е, -ө/, -0, -аарай⁴, -аач⁴, -г, -уузай², -аасай⁴)-өөр хэлбэржсэн үйл өгүүлэхүүний дараа даа⁴, байз, аа⁴, л, уу², билээ зэрэг даган чимэх баймж үг гэсэн нэмэлт хэлбэрүүд цувран орж төрөл бүрийн утга илтгэдэг бөгөөд эдгээр нь тухайн нөхцөлийн дараа орохдоо **“биеэр төгсгөх нөхцөл + чимэх үг, баймж үг”** бүтэц бүхий загварыг үүсгэж эрчимжүүлсэн давхар утга илтгэдэг. Тухайн нэмэлт хэлбэрүүд заримдаа 3 давхарлан цуварч орох тохиолдол байх ба **“биеэр төгсгөх нөхцөл+чимэх үг; биеэр төгсгөх нөхцөл+чимэх үг, чимэх үг; биеэр төгсгөх нөхцөл+чимэх үг, чимэх үг, чимэх үг”** гэсэн бүтцийг үүсгэдэг ажээ. Гэхдээ биеэр төгсгөх 10 нөхцөлөөс –сугай², -гтун², -тугай² нөхцөлийн дараа дээр дурдсан нэмэлт хэлбэрүүдээс тохиолддоггүй байна. Мөн монгол хэлний биеэр төгсгөх нөхцөлүүд дангаараа баймж утга илтгэх нь цагаар төгсгөх нөхцөлөөс илүү боломжтой байдаг учраас тухайн нөхцөлийн дараа нэмэлт хэлбэрүүд харьцангуй бага тохиолддог ажээ. Үүнээс үзвэл, энэхүү нөхцөл нь I, II, III биед холбогдон гурван биеийг ялган зааж үйлийг төгсгөх бөгөөд өгүүлэгч этгээдийн хэлэх зорилго, аялгаас хамааран нөхцөл тус бүр өөрөө төрөл бүрийн баймж утга илэрхийлэхээс гадна хойноо даган чимэх үг авч эрчимжүүлсэн давхар утгыг илтгэдэг зэрэг олон онцлогтой байна.

Тухайлбал, үйлийн биеэр төгсгөх зарим нөхцөлөөр хэлбэржсэн өгүүлэхүүний дараа орж тодорхой баймж утга илтгэх үгийн баймж харьцааны талаар “-даа (-дээ, -доо, -дөө)” хэмээх чимэх үгээр жишээлэн авч үзье. Энэ чимэх үгийг монгол хэл шинжээчид гол төлөв “батлах сул үг” хэмээн нэрийдэж ирсэн. Харин академич Ш. Лувсанвандан “үгэлбэрийн онцлох нөхцөл” хэмээн тодорхойлсон байна. Эрдэмтэн судлаач П. Бямбасан дээрх ангилал дээр үндэслэн “дагаж магадлан онцлох чимэг” гэж ялган үзжээ [Бямбасан 2006]. Харин эрдэмтэн Ц. Өнөрбаян “...-даа (-дээ, -доо, -дөө)” чимэх үгээр батлах утга илэрдэггүй, харин хэлэгч этгээд өөртөө хандан

эргэцүүлэх хийсвэр баймж утга илэрнэ. Учир нь чимэх үгс нь өгүүлэхүүний дараа дангаараа орвол утга нь нэлээд тодорхой, харин давхарлан орвол хийсвэр бөгөөд нийлмэл утга илтгэнэ” хэмээн дурдсан байна [Өнөрбаян 1996]. Мөн монгол хэл судлаач, эрдэмтэн Ю. Мөнх-Амгалан “...өгүүлэхүүний хойно баймж үг, баймж сул үгийг үндсээр нь хамжуулан холбож тодорхой цуваанд цувруулан оруулснаар гол ба гол бус баймж утга –сэтгэлийн байдал илэрхийлэх харьцаа – яруу илтгэх харьцаа гэсэн шугамаар өгүүлэмжийн баймж утгын багтаамж, утгазүйн ачаалал ихсэн мэдээллийн цар хүрээ нь тэлэн өргөсч ирдэг байна” гэж тодорхойлжээ [Мөнх-Амгалан 1998].

Бидний авч үзэж буй үйлийн биеэр төгсгөх нөхцөлийн баймж утгын багтаамж их тул хойноо цөөн сул үг авч нэмэлт утга илтгэдэг ажээ. Үүнд:

Нэгдүгээр биеэр төгсгөх өөрөө зорин шийдэх утгатай –я /-е, -è/ нөхцөлийн дараа орох –даа⁴ чимэх үг нь тухайн үйлийг гүйцэтгэхээр баттай шийдсэн, шийдэн шаардсан, няцсан, шийдэн эргэлзсэн, дурамжхан шийдсэн зэрэг нэмэлт баймж харьцааг заадаг байна. Жишээ нь:

– Нарны эртэд хөдөлөе дээ, сайн сууж байгаарай. (Л.С.)

– “Олигтой боолт зүүлт байхгүй” гэж хэлэх гэснээ сэтгэлий нь зовоохоо больё доо хө гэж бодов. (С.У.)

– Надад ч олон найз байх биш дээ. (С.У.)

– Больё доо, би тэрийг чинь хийж чадахгүй. (Л.С.)

Хоёрдугаар биеэр төгсгөх захиран тушаах утга бүхий тэг нөхцөлийн хойно орох –даа⁴ чимэх үг нь зөвлөсөн, шаардсан, гуйн хүссэн, зөвшөөрч захирсан нэмэлт баймж утгыг илтгэдэг байна. Жишээ нь:

– За, Ганцэцэг минь арван хоног сангийн аж ахуйнуудаар яваад ир дээ, хэсэг эмч нар... гээд дуугүй болов. (Т.Б.)

– Хэлсэн, хэлээгүй яах вэ? Та гар даа. (З.С.)

– За ингээд хэвтээд бай даа, хөөрхий. (Д.У.)

Гуйн хүсэх утгатай –аарай⁴ нөхцөлийн дараах –даа⁴ чимэх үг нь хэлэх зорилго, аялга, сэтгэлийн хөдөлгөөнөөс шалтгаалан даалгах, ерөөх, шаардах нэмэлт утга илэрхийлнэ.

– Орой болоход мордоход бэлэн болоорой доо. (Н.Б.)

– Энэ хэргийг гүйцэтгэхэд завшааныг чадвартайгаар гаргаж өгсөн хүнд та бас баярыг хүргээрэй дээ. (Н.Б.)

– Юун сэнтэг хөгшин бэ гэж бүү бодоорой доо. (З.Б.)

Мөн шаардан хүсэх утгатай –аач⁴ хэмээх нөхцөлийн дараа орох –даа⁴ чимэх үг нь гуйн хүсэх, шаардах утгаар нэмэн дэлгэрүүлдэг байна.

– Алив намайг нэг өндийлгөөд орхиоч дээ, юм хэлмээр байна. (О.Ц.)

– Эгиймаа минь, чи намайг итгээч дээ! хэмээн уйлан алдан дуу нь тасалдав. (С.Ж.)

- Биднийг бүгдийг нь нүүлгэж аваад яваач дээ. (Н.Н.)
- Битгий уйлаач дээ, уурхайч хүүтэй байхад гутамшигтай юм ер алга.

(З.С.)

Гуравдугаар биеэр төгсгөх зөвшин хүсэх утгатай –г; мөрөөдөн хүсэх утгатай –аасай⁴ нөхцөлүүдийн дараа –даа⁴ чимэх үг орсноор зөвшөөрсөн, ерөөсөн, машид хүсэн мөрөөдсөн, эсвэл мөрөөдөж цөхөрсөн нэмэлт баймж утгыг ч илтгэдэг ажээ.

- Өөрөө надтай уулзаг дээ. Ярилцаж байж болъё хэмээн дарга залуу хэлэв. (Ш.В.)

- Нэг нэгэндээ үг хэлээр ч болов нэмэр жийрэг болог доо гэхдээ хүүгээ явуулчихсан юм. (Б.Б.)

- Энэ эгч, энэ эгчийн түлсэн гал хоёр таныг дулаацуулаг дээ. (Д.М.)

- Энэ тэнгэрийн муухайд саадгүй л яваад хүрээсэй дээ гэж амандаа ганцаар ярин гэр өөдөө хандав. (С.Д.)

- Бушуухан наадам нь болоосой доо билээ, энэ хүүгийн сэтгэлийг нэг амраах юмсан. (С.У.)

- Надад ийм сайхан авъяас байдаг ч болоосой доо. (С.У.)

Дээрхээс үзэхэд, монгол өгүүлбэрийн захын бүтцэд хамаарах нэмэлт хэлбэрүүдийн дотроос дангаар орсон –даа⁴ чимэх үг нь биеэр төгсгөх 6 нөхцөлийн дараа даган утгыг нэмэн дэлгэрүүлж байгаа нь төрөл бүрийн баймж утга илтгэн мэдээллийн агуулгыг улам баялаг, олон талтай, яруу сайхан болгодог, хэрэглээний хувьд илүү үүрэгтэй, бүтээлч болох нь харагдаж байна.

Мөн үйлийн биеэр төгсгөх нөхцөлүүдэд баймж утга голлодог тул зарим нөхцөлд цөөн тооны чимэх үг дагалдан нэмэлт утга илрүүлжээ.

Биеэр төгсгөх нөхцөлөөр хэлбэржсэн өгүүлэхүүний дараа орсон даган чимэх үг бүхий өгүүлбэрийн дийлэнх хувь нь гуйсан, хүссэн, зөвшөөрсөн утга голлож, зөвлөсөн, шаардсан, цөхөрсөн утга нь дагалт шинжтэй байна.

Түүнчлэн –я, –е, –ё нөхцөлийн дараа –даа⁴ хэлбэр илүү олон тохиолдож байгаа нь тухайн нөхцөлийн дангаараа болон нэмэлт хэлбэрээр илрүүлэх баймж утгын багтаамж бусдаасаа их байна гэж үзэж байна.

Үүний адилаар бусад нэмэлт хэлбэрүүд биеэр төгсгөх нөхцөлийн дараа орж нэмэлт утга хэрхэн гаргаж байгааг хойшид дэлгэрүүлэн тайлбарлах болно.

Монгол хэлний өгүүлбэрийн бүтэц, утгын багтаамж, мэдээллийн цар хүрээ нь төвөөс зугтах чиглэлээр буюу өгүүлэхүүний дараа янз бүрийн нэмэлт хэлбэр дагуулахад улам өргөжин тэлдэг байна. Өөрөөр хэлбэл өгүүлбэрийн бүтцэд янз бүрийн оруулбар болон нэмэлт хэлбэр ороход өгүүлэмжийн бүтэц задарч утга нь баяжин мэдээллийн хүрээ тэлэх бөгөөд үүрэг нь тодорхой болдог ажээ.

Дүгнэлт

Монгол хэлний биеэр төгсгөх нөхцөл буюу үйлийн төгсгөх нөхцөл нь нэг, хоёр, гуравдугаар биед хамаатаж тодорхой утга илтгэхээс гадна тухайн нөхцөлийн дараа зарим сул үг орж тухайн өгүүлбэрийн илтгэх утгыг өргөн цар хүрээтэй болгон тэлдэг байна. Энэхүү өгүүлэлдээ жишээ болгон –даа⁴ хэмээх сул үгийг авч үзсэн бөгөөд гуйсан, хүссэн, зөвшөөрсөн утга нь голлож, баталсан, эргэлзсэн, зөвлөсөн, даалгасан, ерөөсөн, мөрөөдсөн, шаардсан, цөхөрсөн зэрэг утгууд дагалдан үүсдэг ажээ. Өгүүлбэрийн цөм утгыг хадгалж байдаг өгүүлэхүүн гишүүний дараа орж нэмэлт утга илрүүлж байгаа сул үгс нь тухайн өгүүлбэрийн өгүүлэмжийн агуулгыг баяжуулж, олон нэмэлт баймж утгыг илэрхийлдгээрээ онцлог талтай юм.

Ном зүй

1. Бямбасан 2006: Бямбасан П. Монгол хэлний онол, бүтцийн асуудалд. УБ., 2006.
2. Мөнх-Амгалан 1998: Мөнх-Амгалан Ю. Орчин цагийн монгол хэлний баймжийн ай. УБ., 1998.
3. Өнөрбаян 1996: Өнөрбаян Ц. Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрийн баймж чанар ба зарим чимэх үгийн утга, байр. МУБИС. Монгол хэл шинжлэл. 1996. №1.

Монголын орчин үеийн уран зохиолоос:

1. Банзрагч Н. “Сүүлчийн буу дуу”
2. Бааст Б. “Бэлтрэг Дорж”
3. Баатар Т. “Хайр”
4. Баттулга “Хүүхэн заяа”
5. Ванчаарай Ш. “Хүний мөс”
6. Дашдооров С. “Өндөр ээж”
7. Жаргалсайхан Сан. “Хайрын өглөө”
8. Маам С. “Газар шороо”
9. Надмид Н. “Хүний тавилан”
10. Сандагаа З. “Эр бор харцага”
11. Сандагаа З. “Хүний ганц”
12. Содов Л. “Заяа тавилангийн орчлон”
13. Урианхай Д. “Учрахуй, хагацахуй”
14. Удвал С. “Их хувь заяа”
15. Цэндсүрэн О. “Халуун салхи”

М. Otgonbayar

MODAL MEANING EXPRESSED BY AUXILIARY PARTICLE -DAA⁴ WITH IMPERATIVE VERBAL FORMS

Abstract. *This article is an attempt to reveal the meaning of particles (-daa⁴) in the Mongolian language in six positions with the imperative form of the verb. The meaning conveyed is: suggestions, advice, requests, confirmations, requirements and instructions.*

Keywords: *finite particle -daa⁴, auxiliary words, imperative, modal meaning*